

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2025 оны III улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2025 оны 8-р сарын 19-27-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 24 шинжээдчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2025 оны III улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.3%,
- Эдийн засгийн өсөлт 5.4%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.0%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.2% болно гэж таамагласан байна.

2026 оны II улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.1%,
- Эдийн засгийн өсөлт 5.1%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 11.4%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.1% болно гэж таамагласан байна.

Судалгааны нэгдсэн үр дүн			
Огноо	2025 он 7 сар	2025 он III улирал	2026 оны II улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	9.3%	9.3%	9.1%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	5.6%*	5.4%	5.1%
Төв банкны бодлогын хүү /%/	12.0%	12.0%	11.4%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.1%	17.2%	17.1%
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш /Хугацааны эцэст/	3,587₮	3,602₮	3,690₮

* 2025 оны 2-р улирал

Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2025

I. Инфляц


2025 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын жилийн инфляц 9.3% болж бага зэрэг буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 0.5 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2025 оны III улиралд инфляц мөн адил 9.3%, жилийн дараа 9.1% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын таамаглал




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2025 оны III улиралд инфляц 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.4%, 8.0-8.9 хувийн хооронд байх магадлал 24.1%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2025 оны III улиралд инфляц 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 24.4% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2025 оны III улирал/




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх улирлын түүвэр судалгааны таамаглалтай харьцуулахад бага зэрэг буурсан бөгөөд цаашид энэ түвшинд тогтворжих хандлагатай байна. Шинжээчид 2025 оны III улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 10.3% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 9.3% гэж таамаглажээ (Зураг 3).

Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 9.1, 9.4% байна (Зураг 4).


Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2025 оны III улирал/



II. Эдийн засгийн өсөлт


2025 оны II улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 5.6% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 2.6 нэгж хувиар өндөр гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2025 оны III улиралд 5.4%, 2026 оны II улиралд 5.1% гэж таамаглаж байна (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2025 оны III улиралд 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.6% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2025 оны III улиралд өсөлт 3.0-3.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.4% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2025 оны III улирал/




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх өмнөх улирлын түүвэр судалгааны таамаглалтай харьцуулахад нэлээд нэмэгдсэн бөгөөд цаашид энэ түвшинд тогтворжих хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2025 оны III улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 4.3%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 5.4% байна гэж таамаглажээ (Зураг 7).

Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай адил түвшинд буюу 5.4-5.5% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2025 оны III улирал/



III. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2025 оны III улиралд дунджаар 12.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2026 оны II улиралд 11.4% байна гэж таамаглажээ (Зураг 9).

Зураг 9. Бодлогын хүүний таамаглал




Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2025 оны III улиралд бодлогын хүү 12.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 10).

Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2025 оны III улирал, хариултын тоогоор/



Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2025 оны III улирлын бодлогын хүүг 11.9% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.0% байна гэж таамаглажээ (Зураг 11).


Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2025 оны III улиралд дунджаар 17.2%, хамгийн ихдээ 17.6%, хамгийн багадаа 16.9%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү өнөөгийн түвшинд хэвээр 17.1% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний таамаглал



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2025 оны III улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 17.0-17.3% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2025 оны III улирал, хариултын тоогоор/



Сүүлийн улирлуудад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү харьцангуй тогтвортой байгаатай холбоотойгоор шинжээчдийн таамаглал мөн тогтворжиж байна. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2025

оны III улиралд зээлийн хүүг 17.3% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 17.2% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт

